

ЖАНГАР ТУУЛЬС ДАХЬ ДОМ ШИВШЛЭГ

Г.Нандинбилиг*

Дом шившлэг бол дохио зангаа хийгээд үг авианы ид шидийн хүчээр зорьсондоо хүрэхийг эрмэлзсэн зан аалийн шинжтэй аман зохиолын эртний хэлбэрийн нэг юм. Монгол дом шившлэгийн үүсэл хөгжлийг баримжаалахын тулд Халимагийн болон Шинжааны ойрадын Жангарын туульст уламжилж ирсэн дом шившлэгийн жишээг задлан шинжилж үзлээ.

Дом шившлэгийн тухай хамгийн анх тогтолцоотой судалсан хүн бол Их Британийн хүн судлаач Э.Тайлор болно. Тэрээр 1871 онд “*Баларлаг үеийн соёл*” номдоо “*эртний хүмүүс өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд аливааг дуурайн дүрсэлж үйлдэхийг чухалчилдаг ба энэхүү дуурайн дүрслэх үйлдэл болон түүнээс хүсэн хүлээх үр дүн хоёр нь шалтгаан үрийн шууд холбоотой гэдэгт итгэдэг байжээ*”¹ хэмээн бичжээ. Дом шившлэгийн мөн чанар, утга учрыг ойлгохын тулд эртний хүний сэтгэлгээний өвөрмөц онцлогийг мэдэх хэрэгтэй. Дом шившлэгийн сэтгэлгээний онцлог бол бүх орчлонг нүдэнд үзэгдэх ба нүдэнд үл үзэгдэх гэсэн хоёр тал болгон ухаарч, нүдэнд үл үзэгдэх ертөнцөд нөлөөлж чадах арга байна уу хэмээсэн эрэл хайгуул гэж болно. Өөрөөр хэлбэл, нүдэнд үл үзэгдэх ертөнцөд тусгай дохио зангаа, үйл хөдлөл буюу домын хүчийг, үг хэллэг, авиа дууриа буюу шившлэгийн хүчтэй хавсарган нөлөөлөх гэсэн нийлэг сэтгэлгээ ажиглагдаж байна.

Жангарын туульс дахь дом шившлэгийн жишээ нь хур бороо оруулан түймэр унтраах, хур бороо оруулан амилуулах, эмэгтэй хүнээр гурав алхуулж амилуулах, эдгэрүүлэх, цахиур цахиураар огтлоод цахицын галаар түймэрдээд, тараагаад хаях, шороо атгаж аваад үлээгээд тарнидах, шившээд сум тавих, шившээд цалам шидэх, шагай зулах зэрэг олон зүйлээр тохиолдох боловч дотор нь нарийн ажиглаж үзвэл дараах хоёр зүйлийн дом шившлэг тод ажиглагдаж байна.

- Харвах, мэргэдэх үйл бүтээмжээ дээшлүүлэх дом
- Амилуулах, эс амилуулах дом

Их Британийн хүн судлаач Ж.Фрэзер дом шившлэгийг хүн судлалын ухааны хамгийн гол сэдэв болгон дэвшүүлсэн юм. Тэрээр “*Алтан мөчир*” хэмээх алдарт бүтээлдээ эртний хүний сэтгэлгээний зарчим нь “*ижил шалтгаанаас ижил үр дүн гарах*”, “*хүртээх үйлдэл үргэлжлэн ориших*” гэсэн хоёр зүйлийн зарчим дээр үндэслэсэн гээд улмаар дом шившлэгийг домнох арга зарчмаар нь дуурайх дом (imitative), хүртээх дом (contagious) гэж хоёр ангилсаны дээр “*дуурайх дом нь адил төсөөтэйн зарчим дээр*

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

¹ Э.Б.Тайлор (1989) “*Первобытная культура*” стр.28 Москва

үндэслэсэн байдаг бол хүртээх дом нь хүрэлцэх халдварлах зарчим дээр үндэслэж байна”² гэжээ. Фрэзерийн үзэж буйгаар бол дуурайх дом шившлэг нь ганцаар дангаараа хэрэглэгдэж болдог байхад хүртээх дом шившлэг нь ерөөсөө дуурайх дом шившлэгийг урьдчилан шаардаж байдаг юм.

Австрийн гүн ухаантан, сэтгэл зүйч З.Фройдын үзсэнээр, “Илбэ дом руу хандахыг албаддаг сэдлүүд бол хүний хүсэл юм. Эртний хүнд өөрийнхөө хүслийн хүчин чадалд итгэх асар их итгэл байдаг гэдгийг л зөвшөөрөх учиртай юм. Тэрбээр илбэ домын аргаар бүтээн туурвиж буй бүх зүйл нь мөн чанартаа болох ёстой зүйл байдаг, яагаад гэвэл тэр үүнийг хүсэж байгаа юм”³.

Жангарын туулиар уламжилж ирсэн дом шившлэгийн хамгийн төгс жишээ бол туульсын баатрын харвах, “мэргэдэх” үеийн шившлэг болно. Шинжааны ойрадын Жангарт өгүүлэхээр

...Бөх мөнгөн Шигшрэг харвах болоод...

Сумаа илж үлээгээд

Тэр дөрвийг таширт нь аваад

“Долоон голын эхинд хүрч

Догшин түймэр асаагаад орхиоч” гээд

Хэлэн шившигээд харваад орхихул

Тэр дөрвөн юмыг таширт нь унагаад

Долоон голын эхинд

Догшин түймэр асаагаад одохул нь...⁴

Дээрх жишээнд гарч буй Бөх мөнгөн Шигшрэгийн “сумаа илж үлээх” үйлдэл нь домын хүч болж, мөн түймэр асаахыг хэлэн шившиж буй үгс нь шившлэгийн хүч болж, шившсэн ёсоор болж байна. Эл жишээ нь сумны нисэх чимээ анирыг дуурайгч исгэрэх гийгүүлэгчээс бүтэж, уг үгийн утга чанарыг илтгэж байгаа “шившиг” гэсэн нэр томъёоны үүсгэл “шивших” гэсэн үг өөрөө байж буй явдал юм.

Ийнхүү Жангарын туульсын үгсийн санд “шивших” гэсэн үг байгаагаас гадна түүнтэй төсөөтэй утгаар хэрэглэгдэж буй “тарни”, “ном”, “номын авшиг” гэхчлэн нэрийдэл тохиолдож байна. Жишээ нь:

Тарнийн хар батгана нь

Жингэнэж гарна.⁵

Бат арван хоёр номын авшиг авч байдаг⁶

Чухамдаа эдгээр үгс нь баатарлаг туульс дахь үгийн ид шидэнд итгэх үзлийн уламжлал хувирлыг мэдээлэхийн зэрэгцээ шившлэгийн үе шат нь хэрхэн шашныхаар солигдсон түүхийг харуулж байна. З.Фройдын хэлснээр “Хүн төрөлхтөн ертөнцийг үзэхүйн гурван аугаа үзлийг бүтээсэн нь анимист үзэл, шашны үзэл, шинжлэх ухааны үзэл бөгөөд тэдгээрийн анхдагч болох анимист үзэл бол ертөнцийн мөн чанарыг юу ч эс үлдээн бүрэн дүүрэн тайлбарласан үзэл байж болох билээ”⁷.

² James Frazer (1993) *The Golden bough*. p.11, London

³ Зигмунд Фройд (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. х. 75, Улаанбаатар

⁴ Janggar I (1988) *Mongᠭol tulᠭur bicig-ün cibural*. öbür mongᠭol-un arad-un keblel-ün qoriy-a, х.47

⁵ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 160, Улаанбаатар

⁶ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 177, Улаанбаатар

⁷ Зигмунд Фройд (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. х. 70, Улаанбаатар

Үйл бүтээмжээ дээшлүүлэх энэхүү шившлэгийн хувилбар нь догшин сумаа харвахаас гадна хүлэг морио барих цаламдах, шагай харвах зэрэг хувилбар байдлаар тохиолдож байна. Тухайлбал:

*Ардаас нь адууч овгон баавай
Аргын нарийхан цагаан цалмыг
-Донхан чонын бөгтөргийг нь цохиод одооч
Тошил сайхан зоог нь зүлгээд одооч
Тул хар сээр дээр нь үлээд (даваад) одооч
Хонхын очир чихнээс нь үлээд одооч
Туг сайхан дэл дээгүүр нь шуугиад одооч
Хонхын очир чихнээс нь үлээд одооч
Шугал сайхан хоншоороос нь мөлтрөөд одооч
Өрмийн эш хүзүүнд нь өлгөгдөөд одооч гээд
Хэлэн цөөлдөөд (шидээд) орхихын тэнд
Аргын нарийхан цагаан цалам нь
Донхан чонын бөгтөргийг нь цохиод одов
Тошил сайхан зоог нь зүлгээд одов
Тул хар сээр дээр нь үлээд (даваад) одов
Хонхын очир чихнээс нь үлээд одов
Туг сайхан дэл дээгүүр нь шуугиад одов
Хонхын очир чихнээс нь үлээд одов
Шугал сайхан хоншоороос нь торолгүй
Өрмийн эш хүзүүнд нь ороод одов гэнэ ...⁸*

гэхчлэн Шинжааны Жангарт гарч байна. Амилуулах дом шившлэг нь хүний “үхэл”-ийг даван туулах хүслээс үүдэлтэй. З.Фройд нь “Анимист домын зонхилгогч зарчим нь сэтгэлгээний хамгийг чадагч, төгс хүчинд байдаг гээд анимист үе шатанд энэхүү хүч чадлыг хүн өөртөө хамаатуулдаг бол шашины үе шатанд тэрбээр бурхан шашинд байраа тавьж өгдөг”⁹ гэжээ. Жангарын тууль дахь амилуулах дом шившлэг нь дотооддоо хөгжлийн шатлал ч гэж болмоор ялгаа бүхий хэдэн хэлбэрээр уламжилсан байна. Үүнд:

1. Эмэгтэй хүнээр алхуулж амилуулах дом шившлэг.
Жишээ нь: Халимаг Жангарт Бөх мөнгөн Шигшрэг хурдан хараа эмээллүүлээд, хамаг зэр зэвээ агсаад Шилтэй Зандан Гэрэл хатандаа хэлэн байгаа нь “Энэ хувгүүнийг талхалж чавчаад тахиа, нохой хоёрт идүүл” гээд мордоод явсны хойно Шилтэй Зандан Гэрэл хатан нь хорлох гэсэн цагт Араг Улаан Хонгор нь

*Ээжээ, Үүнийг алах бол
Намайг ч алагтун гээд дээр нь хэвтээд байв.
Ээжээ, Үүний далд нь орсон сумыг гаргаж өгөгтүн
Ариун шагшаабадтай эм ээж таныг
Гурав алхахаар гарна гээд байхлаар нь
Хувгүүнийхээ сэтгэлийг бодоод
Хоёр алхаад гурав дахь дээр нь
Шархын аман дээр гарч ирчихээд*

⁸ Janggar I (1988) *Mongyol tuluyr bicig-ün cubural*. 6bür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, x.38

⁹ Зигмунд Фройд (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. х. 79, Улаанбаатар

Уналгүй байгаад байв.
 Ээжээ, энэ яагаад ингэв гэж
 Араг Улаан Хонгорын асуусанд
 Харьд ирсний хойт жилд
 Хаврын эмнэг гүүдээ саахаар яваад
 Азрага гүүнд гарсныг тачааж харснаас болж
 Гаралгүй байдаг биз гээд
 Гараа наманчлан сөгдөөд суухад
 Сум нь унаад одов¹⁰

гэж гардаг нь ариун умайт эхийн хэвлийгээс дахин эсний мэндлэхийг дохио зангаагаар дуурайлган бэлгэдсэн домын зүйл билээ.

2. Тэнгэрээс хур бороо оруулж, туульсын баатрыг амилуулах дом шившлэг.

Жишээ нь: халимаг Жангарт Дуутай Жангарын байсан хадад ирээд

Рашиан дээд хур оруулаад
Эзэн Жангараа баатруудтай нь амьдруулж аваад
 Шарын зургаан мянга
 Арван хоёр баатар цуглаад суув.¹¹
 гэх буюу,
 ...Хурдан хөхийн ширүүнээр яваад
 Баруун дөрөө дороосоо шүүрээд
Атга хирийн цагаан шороог атгаж аваад
 Адист богд гэгээний заасан
 Арван зүйлийн догшин бурхны
 Зүрхний тарнийг гурав уншаад
Гурав үлээгээд огторгуйд цацав.
 Цацсан даруй дээр нь
 Дээврийн чинээн
 Дэлбэн хөх үүл цуглараад
 Эрдэнэ билгийн хур
 Эргэн дагаж оров.¹²

гэж гардаг. Энэ жишээнд бурхны шашны нөлөө хүртсэн тал байгаа боловч анх үүслээсээ “задын аргаар хур оруулах” эртний зан үйлтэй холбоотой зүйл болно. Дом гэдэг бол аливаа юм үзэгдлийг дохио зангаагаар орлуулан бэлгэдэх сэтгэлгээний нэр бөгөөд хүний таван мэдрэхүйд өртөж үл болох далд юм үзэгдэл, мөн чанар болон түүний бүхэл цогцолборыг уул таван мэдрэхүйн боломжийн хэрээр дуурайлган орлуулж, бэлгэдэн товчлох үйлдлийг хэлж буй юм.

3. Зандан модны навч цацаад, шившин амилуулах дом шившлэг. Жишээ нь:

... Араг улаан Хонгорынхоо
 Эмнэг цагаан ясы нь аваад
Эв эвт нь оруулаад
“Галбир зандан модны
Эрдэнэ навч мөн болбол

¹⁰ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 20, Улаанбаатар

¹¹ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 97, Улаанбаатар

¹² Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 247,

Улаанбаатар

*Араг улаан Хонгорыг минь
Эдгээж аль гээд зажлаад цацав.
Бүрэлдээд эдгэрэв
Дахиад нэг цацав
Улаан Хонгор унтаж байх шиг болов.
Аманд нь нэг навч хийгээд
Жангар нуугдав.
Хүн ийм удаан унтдаг
Юмсанж л гээд Хонгор босов.¹³*

4. Аманд нь зандан модны навч, эрдэнийн үрэл, үд хүргэдэггүй үен цагаан эм... зэргийг хийгээд амилуулах, түрхээд эдгэрүүлэх дом шившлэг. Жишээ нь:

*Морь бие нь салаад
Дөрвөн хоног ухаангүй болоод хэвтэв
Дээр нь гэнэт
Гурван шар толгойтой
Хүн дэрвэн нисэж ирээд
Энэ юун гэдэг газарт
Хүн морь хоёр
Хэвтсэн нь энэ вэ?
Хойтын буян болох
Ус унд өгөөд
Эдгээн сэргээе гээд
Морь бие хоёрынх нь аманд
Нэг үрэл хийж өгөөд
Нисээд гарав.
Ард нь гэнэт ухаан ороод
Морьтойгоо сэргээд босов.¹⁴*

гэсэн хэдэн зүйл ялгаатай байна.

Амилуулах дом шившлэгийн эхний хэлбэр болох эмэгтэй хүнээр алхуулж амилуулах дом нь эм хүйсээр үр төл, үржил шимийг бэлгэдэх сонгодог жишээ бөгөөд эртний умайн шүтлэгийн тусгал билээ. Эм хүйсэнд итгэх энэ үзэл нь амилуулах домын удаахь хэлбэрт ч ихэд амь бөхтэйгээр уламжилсан болохыг бид мөшгөн үзэж болох юм.

Амилуулах домын удаахь хэлбэр болох тэнгэрээс хур бороо оруулж, туульсын баатрыг амилуулах жишээ нь тэнгэр газрыг эр эм үүтгэлтэй болгон төсөөлөх домог зүйн сэтгэлгээтэй холбоотой. Домын аргаар бороо хурыг урин дуудах буюу бидний нэрлэж заншсанаар “зад барих” ёсны тусгал гэж үзэж болох энэ жишээ нь байгалийн үзэгдлийг хүний хүсэл зоригт захируулах гэсэн дом шившлэгийн язгуур санаа зоригийн нэгэн юм. Эртний энэхүү нийлэг сэтгэлгээг домог зүйн сэтгэлгээ байсан гэж үзвэл дом шившлэг нь түүний аж хэрэглээний тал нь болно.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн бэлгийн үйл хийгээд тэнгэрээс хур бороо орсноор газраас үр жимс дэлгэрэх үржил шимийн бодот байдлыг эндсэн баатрыг амилуулах их хүсэлтэйгээ холбон бэлгэдэх замаар үүссэн эхний энэ хоёр дом нь амилуулах дом шившлэг төдийгүй үржил шимийн дом шившлэгийн хоёр шатыг харуулсан сонгодог

¹³ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 213, Улаанбаатар

¹⁴ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 41, Улаанбаатар

жишээ мөн болно. Фрезер энэ төрлийн домьг дуурайх дом (imitative) гэж нэрлэсэн байдаг. Хэрвээ эндсэн баатрыг амилуулахыг хүсэж байгаа бол эхээс төрөх маягаар эм хүйсийн төлөөллийг санагдуулам ямар нэг зүйлийг хийх ёстой. Жангарын туулийг бүтээгчдийн хувьд энэхүү нөөц боломж нь эмэгтэй хүнээр дээгүүр нь алхуулах дохио зангааны бэлгэдэл хийгээд тэнгэр газрыг эр эм үүтгэлтэйгээр төсөөлсөн домог зүйн нөөц боломж байжээ. Харин соёлын хөгжлийн дараагийн шатанд хур бороо, үржил шимийн дом шившлэгийн оронд зандан модны навч цацаад түрхээд эдгэрэх, аманд нь зандан модны навч, эрдэнийн үрэл, үд хүргэдэггүй үен цагаан эм зэргээр амилуулах домүүд гарч иржээ.

Жангарын туульс дахь дом шившлэгийг давтагдах байдлаас үзэхэд нь өрсөлдөгч дайснаа дараад түүний хүүр биеийг цахиур цахиураар огтлоод цахицын галаар түймэрдээд, тараагаад хаях дом нь баатрын ясыг нь эвлүүлэн эрдэнийн хур оруулаад, эсвэл эмэгтэй хүнээр амилуулах домоос дутахгүй олон тохиолдож байна. Фрезерийн судлан тогтоосноор дуурайх домын үед орон зай ямар ч үүрэг холбогдолгүй байдаг бол хүртээх домын үед адил төсөө биш харин холбоо хамаарал чухал болж, дайсанд хор хөнөөл учруулахын тулд түүний хамаат ямар нэг эд зүйл, үс хумс зэргийг гартаа оруулах нь түүнийг өөрийг нь барьж авсантай адил байдаг. Жангар туульд өрсөлдөгч этгээдийг устгахдаа түүний хүүр биеийг цахиур цахиураар огтлоод тараагаад хаях, нохой шувууд идүүлэх, цахицын галаар түймэрдэх зэргээр яс үсгүй болгох, дахин эвлэж бүтэхээргүй болгон тарааж хаях явдал байдаг. Энэ нь өмнө өгүүлсэн амилуулах домын эсрэгээр буюу дахин амилуулах боломжгүй болгох, эс амилуулах санаа юм. Тухайлбал:

Бөх Мөнгөн шигшрэг...

Малаа цагааныг гар хөлий нь хугалаад

Шаржигнуулан хаяад орхив

Хонгор дараа нь

Махы нь цахиур цахиураар (мэт) огтлоод

Ганга мөрөн далайд хаяад орхив.

Богд Жангар таны хишиг илүү сайн санж

Уулын нэг нар минь унав гээд

*Таван зуун залуугаа дагуулаад харив*¹⁵ (Жангар, 1963, 56)

Өмнөөс нь нар сар болсон сайхан бэр

Ерэн есөн хүч төгссөн идээгээ аваад

.. Идээн унды минь эс эдэлсэн чамайг

Зүрхний чинь эхэнд хар болд хонишоороо

Оруулаад шимэхээр чи мэднэ гээд ...хөөхөд

Буллингарын догшин Хар Санал

...Болд хар хонишооры

Тас тайраад цохин унагаав

Алтан жолоог хариу эргүүлээд

*Махы нь цахиур, цахиураар огтлоод тараагаад хаяв*¹⁶ гэжээ.

¹⁵ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 56, Улаанбаатар

¹⁶ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 63, Улаанбаатар

Цахиур цахиураар огтлоод тараагаад хаях энэ жишээ бол угтаа эрт цагийн хүй нэгдлийн үеийн хүний чулуун багаж зэвсэг, тэр дундаа цахиур чулуун багаж зэвсгийг эрхэмлэн дээдлэх үзэлтэй холбоотой бөгөөд бид олон монгол угсаатны дунд өнөө хүртэл уламжилж ирсэн тайж нарын дом буюу “цахиачийн дом”-ын эх дүр мөн гэж үзэж байна. “Цахиачийн дом”¹⁷ гэдэг бол уг удам, угсаа гарлыг чухалчлан үзэх ёс мэргэшлийн дом шившлэг бөгөөд зөвхөн хан цагаан ястай хүн хийх ёстой байдаг. Баруун монголчууд “цакаач” гэж хэлдэг, халхууд бол “могой яр” гэдэг, бие ороож гардаг (шархны 2 үзүүр уулзвал үхнэ гэдэг) яр өвчний үед зөвхөн хан цагаан ястай, тэнгэр язгууртай тайж хүн харуй бүрийн цагаар гадаа суугаад хэт цахиур цахиж домнодог ажээ. “Тайжсийн дом” ч гэж бас хэлдэг байна. Шившлэгийн ерөнхий утга нь уг өвчин их аюултай өвчин учраас өвчний эзнийг цочроон айлгаж байгаа, өвчинтэй тэмцэж байгаа утгатай байна. “Цахицын гал” гэдэг маань бас хүмүүний анх гал гаргаж авсан ой дурсамжийн зүйл бөгөөд түүнийгээ ариутгалын дээд хэлбэр болгон үзэж байсантай холбоотой юм. Тэгэхээр махы нь цахиур цахиураар огтлоод тараагаад хаяж буй нь сүнснийг сэргэх боломжгүй болгож буй хэрэг бөгөөд энэ тохиолдолд сүнс нь домын объект болж байгаа юм.

3. Фройдын үзэхээр “Домын сэтгэлгээнд сүнс ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй, харин сүнс нь өөрөө домын өртөгч объектууд болдог. Анимизмын цөмийг бүрдүүлэгч дом нь сүнсний тухай сургаалыг бодвол анхдагч бөгөөд түрүү үеийнх билээ. Сэтгэлгээний бүхнийг чадагч хүчийг дом шившлэг дангаараа эзэмшиж байснаа анимизм энэ хүч чадлын нэг хэсгийг сүнсэнд тавьж өгснөөр шашны үүслийн замыг зассан юм”¹⁸. Өөрөөр хэлбэл анимизм өөрөө шашин биш ч гэсэн алс хэтдээ шашин суурилан өндийх тийм угтал нөхцлүүдийг агуулж байсны үндэс нь сүнсний үзэл юм. Дом шившлэгт сүнсний үзэл хэрхэн түрэн орж ирснийг харуулах нэгэн жишээ гэвэл,

Голт улаан зүрхий нь хага татаад орхив

Голт улаан зүрхнээс нь

Гурван салаа түймэр асаад

Гол шиг Жангарыг нөмрөөд авав

Жангар өнгөрсөн олон бурхаддаа залбираад

Өвөг дээд аав ээжээ дуудаад

Билгийн ариун хур хайрлагтун гээд хашгирав

*Билгийн хураар түймрийг унтраав.”*¹⁹ гэсэн дүрслэл болно.

Энэ жишээнээс үзэхэд үеийн өнчин төрсөн Жангар өвөг дээдсийн сүнсэнд хандан тус дэм хүсч буй нь эргэлзээгүй бөгөөд домын хүч болох дохио зангааны оронд залбирах үйл орж ирсэн ч шившлэгийн үг нь ил тод хэвээр үлдсэн байна. Энэ тохиолдолд туульсын баатар нь сүнснээс тусламж хүсч байгаа тул дом шившлэгийн гол шинж болох сэтгэлгээний хүчийг эргэлзээнд оруулсан байна. Бас энэ дашрамд ажиглагдаж буй өөр нэг зүйл бол “шивших” гэсэн үгийн оронд “хашгирах”, “дуудах” гэсэн үгс түрэн орж ирсэн байна.

Дээр өгүүлсэн харвах цаламдах хийгээд амилуулах дом шившлэгийн жишээнд шившиж буй үг хүсэл нь монгол хэлээр ил тод илрэн байсан бол шашны нөлөө бүхий

¹⁷ Баядын Их цагаан тайж ястай, Цэрэнгийн Дамдинсүрэн, 64 настай, эрэгтэй, Увс аймгийн Малчин сум 2-р баг. Энэ хүн тус домыг хийдэг. 2004-8-28-нд тэмдэглэн авав.

¹⁸ Зигмунд Фройд (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. х. 83, Улаанбаатар

¹⁹ *Жангар* (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 209, Улаанбаатар

хожмын дүрслэлд чухам юуг хүсэж буйгаа илтгэх үг шившлэг хийгээд үлээх сацах гэх гэх мэт дохио зангаа нь алга болж, тэрбээр бурхан тэнгэрт байр сууриа тавьж өгсөн нь тод харагдана. Жишээлбэл,

*Хоёр хоноод нэг навч аваад ирэв
Жангар булаагаад авав
Дахиад гүйгээд явчив
Бас гурав хоноод нэг навч аваад ирэв
Жангар бас булаав
Нэгий нь хулганадаа өгөөд эдгээгээд тавив
Уйдсан олон бурхдаа дуудаад
Нэгий нь зажлаад таашаандаа түрхэв
Бүрэлдээд эдгэрэв.
Нэгий нь зажлаад идээд орхив
Босож гүйгээд явав²⁰*

гэсэн жишээнд домын хүртээх зарчим үйлчилж байгаа мэт боловч бурхдыг дуудах болсноор шившлэгийн хүч арилж, шашны мэдлэг түрж орсон байдал харагдаж байна.

Эцэст нь дүгнэхэд,

1. Жангарын туульс дахь дом шившлэгийн холбогдолтой жишээ баримтуудыг задлан шинжилж үзвэл, сүнсний үзлээс ангид түрүү үеийн дом шившлэгийн сонгодог жишээ хийгээд анимист мэдлэгийн шатнаас шашны мэдлэгийн шатанд шилжих үеийн тод дүр зураг болсон өвөрмөц домүүд ч зэрэгцэн байна.

2. Туульсын баатрын харвах “*мэргэдэх*” үйлс бүтээмжээ дээшлүүлэх дом шившлэг нь **хүслийн бүхнийг чадагч хүчийг** өөртөө агуулсан түрүү үеийн дом шившлэгийн уугуул төрх төлвийг цэврээр хадгалан ирсэн байна.

3. Фрэзерийн судлан тогтоосон домнох арга зарчмын үүднээс авч үзвэл Жангарын туульд дуурайх дом (imitative) хийгээд хүртээх дом (contagious)-ын уламжлал аль аль нь нэлээн өвөрмөц байдалтайгаар оршиж байна. Үүнд:

- Амилуулах дом шившлэгийн эмэгтэй хүнээр алхуулах болон билгийн хур бороо оруулах жишээ болон эс амилуулах домын цахиур цахиураар огтлоод хаях жишээ нь эртний хүний сэтгэлгээний “*ижил шалтгаанаас ижил үр дүн гарах*” адил төсөөтэйн зарчим дээр үндэслэсэн дуурайх (imitative) домын өвөрмөц хэлбэр мөн бөгөөд энэ сэтгэлгээнд сүнснээс тусламж авах биш, харин сүнс нь өөрөө домын өртөгч объектууд болж байна.

- Амилуулах дом шившлэгийн зандан модны навч зажилж цацаад эдгэрүүлэх, аманд нь эрдэнийн үрэл, үд хүргэдэггүй үен цагаан эм хийж амилуулах жишээ нь эртний хүний сэтгэлгээний “*хүртээх үйлдэл үргэлжлэн орших*” хүрэлцэх халдварлах зарчим дээр үндэслэсэн хүртээх (contagious) домын шинжийг хадгалж байна.

²⁰ Жангар (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., х. 211, Улаанбаатар

SUMMARY

Analyzing the instances of magic in the Janggar epic, one finds there are classical details of primitive magic apart from spirit belief also peculiar magic of animist belief before religious one.

According to J.Frazer, traditions of both sympathetic and contagious magic can be found—peculiarly—in the Janggar epic. As sympathetic magic relies on similarity, spirit itself becomes magic object; it does not receive any help from spirit. Some motives can be occurred that relying on contact or ‘contagion’.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Дулам С, Нандинбилиг Г. (2007) *Монгол аман зохиолын онол*. I, Улаанбаатар.
2. *Жангар*. (1963) Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэрсүрэн. ШУАХЗХ., Улаанбаатар
3. *Жангарын туульс*. (1968) БНМАУ-аас сурвалжлан бичсэн Жангарын туульс. АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ. tomus VI, fasc 15, ШУАХЗХ. Улаанбаатар
4. Нандинбилиг Г. (2004) “Монгол дом шивилэг ба нагацыг шүтэх ёсон”, МУИС-ийн “Монгол судлал” эрдэм шинжилгээний бичиг, XXIII боть, Улаанбаатар
5. Фройд З. (2009) *Онгон шүтлэг ба хорио цээр*. Орос хэлнээс орчуулсан Ж.Отгонбаяр, Улаанбаатар.

Монгол бичгээр:

1. *Jangyar*. (1988, 1989, 1996) I, II, III. Mongyol tulγur bicig-ün cubural. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a,
2. Damrinjab B. (2006) *Oyirad-un bayaturliy üliger-ün sudulul. ündüsün-ü keblel-ün qoriy-a*.
3. Nandinbilig G. (2005) “*Mongyol domci ba jarim dalda dom sibsilge*”.- “ögedelejü bui mongyol sudulul, önggeregsen ba iregedüi”. Begejin-ün yeke surγayuli-yin mongyol sudulul-un cubural bicig. ündüsün-ü keblel-ün qoriy-a.

Орос, англи хэлээр:

1. Э.Б.Тайлор (1989) *Первобытная культура*. Москва
2. Tylor E.B. (1871) *Primitive culture*. Vol. 1-2. London.
3. Frazer J. (1993) *The golden bough*. London.